



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/694

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Манай аймагт зохион байгуулсан 99 гэр арга хэмжээний зохион байгуулагч хүндэт зочдын байрны зардал, уулзалтын зардалд 6 019 600 төгрөг, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүд, төлөөлөгч нартай хийсэн уулзалтын зардалд 300 000 төгрөг, архивын улсын үзлэг зохион бэлтгэл ажлын зардалд 300000 төгрөг, Засаг дарга баруун гурван сумдад ажилласан зардалд 1 100 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 7 719 600 төгрөг /Долоон сая долоон зуун арван есөн мянга зургаан зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ

